

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “жагсаалт, тэтгэмж” гэсний дараа “тооцож,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

“5.1. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас олгоно.”

2/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:

“11.1. Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож олгоно.”

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “3” гэснийг “6” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “9” гэснийг “12” гэж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “9” гэснийг “12” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ